

**FRIEDRICH
EBERT** 
STIFTUNG



**MONGOLIAN
INSTITUTE FOR
INNOVATIVE
POLICIES**

МОНГОЛЫН ЗАЛУУЧУУД БА ДЭЛХИЙ ДАХИН-2021 ОН

(Олон нийтийн санаа бодлын судалгааны дүн)

Улаанбаатар хот 2021



ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, ГАДААД БОДЛОГЫН ТАЛААР ЗАЛУУЧУУД ЮУ ГЭЖ ХАРИУЛАВ?

Энэхүү судалгааг Фридрих-Эбертийн сангаас Монголын бодлогын инновацийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулав. Энэ судалгааны агуулга, мэдээллийн үнэн зөв нь Фридрих-Эбертийн сан болон Монголын бодлогын инновацийн хүрээлэнгийн байр суурьтай нийцэж байх албагүй болно.

Судалгааны баг: Л. Бямбаханд
 Н. Соёлгэрэл
 Ө. Пүрэвсүрэн
 М. Сайнбуян
 Ж. Мэндээ
 Д. Бямбажав
 Ц.Ариунболд

ISBN 978-9919-9870-3-9

@ ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон Монголын бодлогын инновацийн хүрээлэнгээс эрхлэн гаргав. Уг бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул зөвшөөрөлгүйгээр болон эшлэлгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах, арилжааны зориулалтаар хэвлэн нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно.

**Олон улсын харилцаа, гадаад бодлогын талаар
залуучууд юу гэж хариулав?**

(Олон нийтийн санаа бодлын судалгааны дүн)

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

Залуучууд гадаад бодлого, олон улсын харилцааг сонирхдог уу? 4

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

Дэлхий дахинд тулгамдсан асуудал, улс орнуудын тухай тэд юу хэлэв? 6

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

Монгол улсын гадаад бодлого ба залуусын санаа бодол 9

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

Зөөлөн хүчний бодлого ба шинэ залуу үе 17

ДҮГНЭЛТ 19

ХАВСРАЛТ 22

ОРШИЛ

Олон улсын байдал, гадаад бодлого, улс орнуудын талаарх залуусын төсөөлөл, үнэлэмжийг тусгайлан судалж, олон нийтийн санаа бодлыг тандсан судалгаа өмнө нь Монголд хийгдэж байгаагүй юм. Тодруулбал, олон судалгааны байгууллага, хүрээлэнгээс нийгэм, улс төрийн тодорхой асуудлаарх иргэдийн санаа бодлыг тандан судлахдаа Монгол Улсын хоёр хөрш болон “гуравдагч хөрш” орнуудын талаарх нийт иргэдийн санаа бодлыг тандсан асуултуудыг багтаасан боловч эдгээр нь нийгэм, эдийн засаг, улс төрийн өргөн хүрээг хамарсан учраас олон улсын харилцаа, гадаад бодлоготой холбоотой тодорхой асуудлуудын хүрээнд иргэдийн, тэр дундаа залуучуудын санаа бодлыг гүнзгийрүүлэн судлах боломжийг хязгаарлаж байсан. Ийм учраас та бүхэнд толилуулж буй энэхүү судалгаа нь дээр дурдсан судалгааны шаардлагыг шийдвэрлэхэд чиглэснийг онцлох нь зүйтэй юм.

Гадаад бодлогын асуудлаарх аливаа шийдвэрийг гаргах, бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэхэд шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдын санаа бодолд голлон тулгуурлахын зэрэгцээ энэ чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн, судлаач, шинжээчдийн байр суурийг тодорхой хэмжээнд харгалзан үздэг боловч иргэд, тэр дундаа улс орны ирээдүй болсон залуу үеийн дуу хоолойг сонсох, тэд олон улсын харилцаа, дэлхий дахины нөхцөл

байдлыг хэрхэн үнэлж дүгнэдэг, төр, засгийн зүгээс гадаад орнуудын талаар ямар бодлого явуулбал зохилтой талаар ямар байр суурьтай байдаг зэргийг нь төдийлөн авч үзэхгүй орхигдуулж байна. Гэтэл аливаа ардчилсан улсын гадаад бодлогын шийдвэр гаргалтад дотоод нөхцөл байдал, ялангуяа иргэд, сонирхлын бүлгүүдийн оролцоо ихээхэн нөлөөтэй байдаг билээ. Түүнчлэн, Монгол Улсын хэмжээнд залуучууд гадаад ертөнцийн талаарх мэдээллийг хаанаас, ямар байдлаар хүлээн авч байгааг, тэд гадаад улс орон, хэл, соёлыг хэрхэн үнэлж эрэмбэлдгийг зохистой түүврийн хэмжээнд судалсан судалгаа хийгдээгүй байна.

Иймд 18-35 хүртэл насны залуусын олон улсын харилцааны талаарх ойлголт, үнэлэмж, мэдлэг, мэдээллийн түвшин, гадаад бодлогын асуудлаарх байр суурь, бусад улс орнуудын үнэлэмжийг тодруулах зорилгоор энэхүү судалгааг Монголын бодлогын инновацийн хүрээлэн ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр авч, судалгааны үр дүнг танилцуулж байна. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2021 оны 9-10 дугаар сард Улаанбаатар, Эрдэнэт хотууд болон Булган, Төв аймгуудад гүйцэтгэсэн бөгөөд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон нийт 1809 хүн оролцлоо. Мөн судалгааны явцад 11 хүнийг хамруулсан фокус бүлгийн ярилцлага зохион байгуулсан юм.

НАЙМАН ГОЛ ДҮГНЭЛТ

1. Монголын залуучуудын 80 орчим хувь нь гадаад мэдээ, олон улсын үйл явдлын мэдээг ямар нэг байдлаар сонирхож байна. Энэ нь залууст ирээдүйд улс орны гадаад бодлогыг тодорхойлоход чухал суурь ойлголт болох бөгөөд олон улсын харилцааны талаар баримталж буй олон нийтийн ерөнхий дүр төрхийг харуулж чадах юм.
2. Судалгаанд оролцсон залуусын 68 хувь нь манай улс Төв Азийн бүс нутагт хамаарна гэж хариулжээ. Зүүн Хойд Азийн улс орнуудад монголчууд олноор амьдарч, ажиллаж байгаа боловч газар зүй, түүх, соёлын нийтлэгийн тухайд Монгол Улс нь Төв Азид хамаарна гэж залуучууд үзэж байгаа нь сонирхолтой дүн юм.
3. Гадаад орнуудын тухай ерөнхий ойлголтыг судалж үзэхэд залуусын 80-аас дээш хувь нь БНСУ, ОХУ, Япон, АНУ зэрэг улсуудын талаар эерэг ойлголттой бол БНХАУ-ын талаар зөвхөн 49 хувь нь эерэг ойлголттой байна. Дэлхийн хоёр нөлөө бүхий улсыг онцлон ирээдүйн төсөөллийг тодруулахад дийлэнх нь Хятад улс дэлхийн эдийн засгийг тэргүүлэгч улс, ирээдүйд дэлхийн асуудлыг шийвэрлэгч улс болно гэж үзэж байгаа бол АНУ-ын нөлөө ирээдүйд нэмэгдэнэ гэж залуусын 38 хувь нь л үзсэн байна.
4. Монгол Улсын гадаад бодлогын хувьд гадны хөрөнгө оруулалтыг татаж, тогтвортой хадгалах, гадаад худалдааг төрөлжүүлэх асуудалд хамгийн их анхаарал хандуулах ёстой. Уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай манай улсын хувьд байгалийн баялагийг зүй зохистой ашиглаж чадвал хурдацтай хөгжиж чадна гэж залуучууд үзэж байна.
5. Залуу үеийнхэнд гадаад дуу хөгжим, кино урлагаар дамжсан зөөлөн хүчний бодлого багагүй нөлөө үзүүлж байна. Ялангуяа Англи-Америк, Солонгос кино, дуу хөгжим, хэл соёлыг залуучууд даган дуурайх хандлага түгээмэл байгааг тус судалгааны дүнгээс харж болно.
6. Судалгаанд оролцсон залуусын 42 хувь нь шашны байгууллагын үйл ажиллагааг хатуу хянах шаардлагатай гэж үзлээ. Энэ нь Монгол Улсын иргэн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй боловч олон улсад үйл ажиллагааг нь хориглосон шашны байгууллагууд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой нийгмийн эсэргүүцэл байж болох юм.
7. Олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагуудын талаар залуучууд мэдлэг, мэдээлэл

багатай байна. Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад Монгол Улс элсэх тухай асуухад 53 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

8. Харин Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа талаар


асуултад мэдэхгүй гэсэн хариулт гараагүй бөгөөд нийт оролцогчдын 77 хувь нь Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Залуучууд гадаад бодлого, олон улсын харилцааг сонирхдог уу?

Монголын залуучууд гадаад мэдээ, олон улсын үйл явдлыг багагүй сонирхдог байдал ажиглагдлаа. Гурван хүн тутмын нэг нь гадаад мэдээг “Их сонирхдог” гэж хариулсан бол нийт оролцогчдын тал хувь нь дунд буюу гадаад асуудлыг хааяа сонирхдог гэж хариулжээ. Харин

оролцогчдын 6 хувь нь гадаад мэдээг огт сонирхдоггүй, 14 хувь нь бага зэрэг сонирхдог гэж хариулсан байна. Хүйсээр нь ангилж үзэхэд оролцогчдын хариултад онцын ялгаа ажиглагдсангүй. Их сонирхдог гэсэн хариултыг эрэгтэй оролцогчид арай илүү сонгожээ (График 1).


График 1: Та гадаад мэдээг хэр их сонирхдог вэ?



Судалгаанд оролцсон залуусын олонхи буюу 40.2 хувь нь олон улсын үйл явдал, гадаад мэдээллийг нийгмийн сүлжээний хэрэгсэл болох фэйсбүүк, твиттер зэргээс хүлээн авч байна. Телевиз, мэдээллийн

сайтууд залуусын мэдээллийн гол эх сурвалжид тооцогдсон хэвээр байгаа бол ФМ, Радио, сонин хэвлэл, найз нөхдийн ам дамжсан яриа зэрэг нь мэдээллийн чухал хэрэгсэлд тооцогдохгүй байна (График 2).


График 2: Та гадаад мэдээг гол төлөв ямар эх сурвалжаас авдаг вэ?



Залуучуудын 55 хувь нь монгол хэлээр, 35 хувь нь англи хэлээр хилийн чанадад олон улсын үйл явдлын мэдээг хүлээн авч байна. Энэ нь залуучуудын

дунд англи хэлний хэрэглээ өндөр байгааг харуулж байна. Харин бусад хэлний хэрэглээ маш бага байгааг тус судалгааны дүн харууллаа (График 3).

График 3: Та гадаад мэдээг гол төлөв ямар хэл дээр авдаг вэ?



ХОЁРДУГААР БҮЛЭГ. Дэлхий дахинд тулгамдсан асуудал, улс орнуудын тухай тэд юу хэлэв?

Дэлхий дахины тулгамдсан асуудлын жагсаалтаас судалгаанд оролцсон залуус цар тахал, ядуурал, эдийн засгийн хөгжлийн асуудалд тэргүүлэх ач холбогдол өгчээ. Өнөөгийн цар тахлын нөхцөл байдал залуусыг ингэж эрэмбэлэхэд нөлөөлсөн нь дамжиггүй. Залуусын 60 орчим хувь нь уур амьсгалын өөрчлөлтийг дэлхий дахинаа тулгамдаж байгаа асуудал гэж үзсэн бол 40 орчим хувь нь үндэстэн дамнасан гэмт хэрэг |хар тамхи, хүний наймаа| -

ийг дэлхий дахинд тулгамдаж байгаа дараагийн асуудал гэж үзжээ. Ингэхдээ эрэгтэй оролцогчид уур амьсгалын өөрчлөлтөд, эмэгтэй оролцогчид гэмт хэргийн асуудалд илүү ач холбогдол өгсөн байна. Харин дайн мөргөлдөөний асуудалд оролцогчид маш бага ач холбогдол өгсөн бөгөөд энэ нь манай улс харьцангуй зэвсэгт мөргөлдөөн багатай тайван бүс нутаг, дэлхийн хүчирхэг гүрнүүдийн дунд оршдогтой холбоотой байж болох юм (График 4).

График 4: Дэлхийд тулгамдаж байгаа асуудал




Дэлхийн зарим улс орнуудын тухай ойлголт, төсөөллийг судалж үзэхэд залуусын дийлэнх нь буюу 80-аас дээш хувь нь БНСУ (86), ОХУ (85), Япон (84), АНУ (82) улсуудад эерэг, ерөнхийдөө эерэг гэсэн хувилбарыг сонгосон бол БНХАУ-ыг дөнгөж 49.3 хувь нь эерэг гэж дүгнэжээ. Залуучуудын 44.1 хувь нь БНХАУ-д сөрөг хандлагатай байгаа нь бусад орнуудтай харьцуулахад өндөр байгаа юм. Азийн орнуудаас Япон,

Өмнөд Солонгос улсын талаар хамгийн эерэг төсөөлөлтэй байна (График 5).

Эдгээр улсаас дэлхийн хоёр нөлөө бүхий улсыг сонгон залуучуудын ирээдүйн төсөөллийг тодруулахад 76 хувь нь Хятад дэлхийн эдийн засгийг тэргүүлэгч улс болно гэдэгтэй санал нэгдсэн хэдий ч судалгаанд оролцогчдын багагүй хэсэг нь тус улсыг ирээдүйд эзлэн түрэмгийлэгч болно хэмээн үзсэн нь

График 5: Дараах улсуудын талаарх таны ойлголт



анхаарал татаж байна. Нөгөө талаар, бага хэсэг нь Хятад улсыг дэлхий нийтэд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэйг хүлээн зөвшөөрчээ. Харин Хятад улс ирээдүйд энх тайвныг эрхэмлэгч улс байна гэж маш бага хувь нь үзжээ (График 6).

Олон улсын харилцаанд АНУ-ын ирээдүйд гүйцэтгэх үүргийн тухай залуусын төсөөллийг тандаж үзэхэд 38 хувь нь тус улсын нөлөө ирээдүйд нэмэгдэнэ, 30 хувь нь нөлөө нь хэвээр байна, харин 15 хувь нь нөлөө нь буурна хэмээн хариулж байна (График 7).

График 6: БНХАУ-ын ирээдүйн тухай төсөөлөл




График 7: АНУ-ын ирээдүйн тухай төсөөлөл



Залуучууд дэлхийн улс орнуудын удирдагчдаас ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путин, БНХАУ-ын дарга Си Зиньпин нарыг улс орноо хамгийн сайн, үр дүнтэй удирдаж байна хэмээн үзжээ. Фокус бүлгийн ярилцлагын үеэр энэ асуултыг тодруулахад, ХБНГУ-ын канцлер асан Ангела Меркелийг сайн удирдагчийн тоонд оруулан нэрлэсэн

нь залуучууд хамгийн сайн удирдагчийг тодорхойлохдоо жендэрийн хувьд нэг талыг барьсан байдлаар хандаагүйг харуулж байна. Мөн тухайн улсын удирдлагын арга барилаас шалтгаалан олон улсад эзлэх байр суурь, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөж байгааг залуучууд онцолж байгаа юм (График 8).


График 8: Таны бодлоор дараах гадаад орны удирдагчдаас хэн нь улс орноо сайн удирдаж байна вэ?



Олон улсын байгууллагуудын тухайд, НҮБ-ыг залуучууд бүгд мэддэг, Европын холбоог дийлэнх нь мэддэг бол Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын

талаар залуучуудын дийлэнх нь мэдэхгүй байв. Дээд, тусгай мэргэжлийн сургууль, бүрэн дунд боловсролтойгоос үл хамааран, залуучуудын олон улсын байгууллагуудын талаар өгсөн хариулт ойролцоо байна (График 9).

График 9: Та дараах олон улсын байгууллагуудыг мэдэх үү?




ГУРАВДУГААР БҮЛЭГ. Монгол улсын гадаад бодлого ба залуусын санаа бодол

Монгол Улс Төв Азийн улс уу, Зүүн Хойд Азийн улс уу? гэсэн асуултад судалгаанд оролцсон залуусын 68 хувь нь манай улс Төв Азийн бүс нутагт хамаарна гэж хариулсан бол 22 хувь нь Зүүн Хойд Азийн бүс нутагт хамаарна гэж үзжээ. Эдгээр хариултын нийлбэр 90 орчим хувийг эзэлж байна (График

10). Хэдийгээр Зүүн Хойд Азийн улс, орнуудад монголчууд олноор амьдарч, ажиллаж байгаа боловч газар зүй, түүх, соёлын нийтлэгийн тухайд Монгол Улс нь Төв Азид хамаарна гэдгийг залуучууд фокус бүлгийн ярилцлагын үеэр онцолж байсан юм.


График 10: Таны бодлоор Монгол Улс доорх бүс нутгийн алинд нь хамаарах вэ?



Монгол Улсын гадаад бодлогын хамгийн чухал гурван асуудал нь нэгдүгээрт, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хоёрдугаарт, гадаад худалдааг төрөлжүүлэх, гуравдугаарт, гадаад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах гэж судалгаанд оролцогчид

үзжээ (График 11). Уул уурхайн баялаг ихтэй орны хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг татаж тогтвортой ажиллуулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж чадвал Монгол Улс хөгжихөд тийм ч хэцүү биш гэж фокус бүлгийн оролцогчид онцолж байна.

График 11: Монгол улсын гадаад бодлогын хамгийн чухал асуудлууд



Монгол Улсад ойрын хугацаанд болон ирээдүйд гаднаас учирч болох хамгийн ноцтой аюул заналд судалгаанд оролцогчдын 87 хувь нь эдийн засгийн хувьд бүрэн хараат болох гэж хариулсан бол 60 хувь нь халдварт өвчин, 55 хувь нь гадны соёл, шашны нөлөө гэж

хариулсан байна. Залуус цэргийн хүчээр эзлэн түрэмгийлэх аюулаас илүү гадны цахим халдлагад түлхүү ач холбогдол өгч байна. Эндээс үзэхэд эдийн засаг, соёл, цахим орчноор дамжих аюул заналд залуучууд илүү санаа зовниж байна (График 12, 13).

График 12: Өнөөгийн байдлаар гадаад улсаас Монгол Улсад учирч болох аюул занал




График 13: Ойрын 10 жилд гадаад улсаас Монгол Улсад учирч болох аюул занал



Монгол Улс олон улсын тавцанд өөрийгөө таниулахад үндэсний уламжлал, түүх соёл, байгалийн үзэсгэлэн, унаган төрхөө сурталчлах нь хамгийн оновчтой алхам гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь үзжээ. Мөн монгол хүний чадварыг харуулах нь зүйтэй хэмээн судалгаанд оролцогчдын 55 орчим хувь нь

хариулсан байна (График 14). Ялангуяа, фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын зүгээс бололцоо, нөхцлийг хангаж өгсөн тохиолдолд монгол залуучууд дэлхийд чадвараа харуулах бүрэн боломжтой гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн юм.


График 14: Таны бодлоор Монгол Улс олон улсын тавцанд өөрийгөө таниулахад аль нь хамгийн чухал ач холбогдолтой вэ?



Судалгаанд оролцогчдын 18.5 хувь нь манай улсын төр, засгийн тэргүүн нарын гадаад айлчлалыг огт үр дүнгүй, 60.3 хувь нь зарим талаар үр дүнтэй, ердөө 7.3 хувь нь маш үр дүнтэй гэж хариулжээ. Эндээс үзэхэд, төр, засгийн тэргүүн нарын гадаад

айлчлалын зорилго, хүрсэн үр дүнг олон нийтэд, ялангуяа залуучуудад ойлгомжтой байдлаар сурталчлан таниулах шаардлагатай байна. Оролцогчдын 13.9 хувь нь энэ асуултад хариулж чадахгүй байна (График 15).

График 15: Монгол Улсын төр, засгийн тэргүүн нарын гадаад айлчлалыг хэрхэн үнэлэх вэ?



Монгол Улс Ковид-19 цар тахалтай тэмцэхэд ОХУ, БНХАУ хамгийн их тусалж байна гэж хариулжээ. Эндээс харахад Ковид-19 цар тахалтай тэмцэхэд Япон, АНУ, Европын холбоо буюу гуравдагч хөршүүдээс үзүүлж буй тусламж, дэмжлэгийн талаар залуучууд мэдээлэл багатай байна (График 16).

Олонулсын байгууллагын хувьд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага илүү их тусалж байгааг залуучууд онцолсон нь энэ байгууллагын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр илүүтэй дурдаж байгаатай холбоотой байж болох юм (График 17).

График 16: Таны бодлоор Монгол Улс Ковид-19 цар тахалтай тэмцэхэд аль улс илүү их тусалж байгаа вэ?






График 17: Таны бодлоор Монгол Улс Ковид-19 цар тахалтай тэмцэхэд олон улсын аль байгууллага илүү их тусалж байгаа вэ?



Монгол Улсын эдийн засаг гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжаас ихээхэн хамааралтай. Залуусын хувьд Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банкнаас түлхүү зээл,

тусламж авах нь зүйтэй гэж хариулжээ. Харин улс орнуудын хувьд ОХУ, Японы зээл тусламжид илүүтэйгээр найдах нь зүйтэй хэмээн залуучууд дүгнэж байна (График 18).

График 18: Монгол Улс хэнээс түлхүү зээл, тусламж авбал аюулгүй байдлын хувьд зүйтэй вэ?



Хөрш орнуудын талаар залуусын сэтгэгдлийг судалж үзэхэд 90 орчим хувь нь БНХАУ болон ОХУ бол Монгол Улсын ойрын түнш гэж хариулсан бөгөөд манай улсын ирээдүйн хөгжилд маш их нөлөөтэй

хэмээн 60 орчим хувь нь үзэж байна. Бусад орнууд болох Япон болон АНУ-ын хувьд дунд зэрэг ойрын түнш, ирээдүйн хөгжилд их нөлөөтэй гэсэн хувилбарыг арай илүү сонгожээ (График 19, 20).

График 19: Таны бодлоор эдгээр улсууд Монгол Улсын хувьд хэр ойрын түнш вэ?





График 20: Таны бодлоор Монгол Улсын ирээдүйн хөгжилд дараах улсууд хэр их нөлөөтэй вэ?



Монголын залуучуудын хувьд БНХАУ-ыг нэг талаар “болгоомжлох ёстой улс”, нөгөөтэйгүүр “эдийн засгийн боломж” гэж хардаг, мөн хуучны түнш, хөгжлийн загвар улс хэмээх хариултыг сонгосон

байна (График 21). Харин ОХУ-ын тухайд эдийн засгийн боломж, хуучны түнш, хөгжлийн загвар гэсэн хариултыг илүү сонгожээ. (График 22).

График 21: Та БНХАУ-ыг ямар байдлаар хардаг вэ?






График 22: Та ОХУ-ыг ямар байдлаар хардаг вэ?



Хоёр хөршийн тухай хариултуудыг харьцуулж үзвэл сонирхолтой дүр зураг гарч байна. ОХУ-ыг хуучны түнш, эдийн засгийн боломж, хөгжлийн загвар улс гэж

харж байхад БНХАУ-ын хувьд илүүтэйгээр болгоомжлох ёстой улс, аюул занал, дээрэнгүй их гүрэн гэсэн хариултыг оролцогчид сонгожээ (График 23).

График 23: Та ОХУ болон БНХАУ-ыг ямар байдлаар хардаг вэ?



Залуучуудаас гадаад бодлогын холбоотой зарим асуудлаарх байр суурийг тандлаа. Далай ламын айлчлалаас болоод Монгол Улсад эдийн засгийн хохирол учирдаг учраас Далай ламыг айлчлуулах шаардлагагүй гэж 28 хувь нь үзсэн байхад, 32 хувь нь эсрэг байр суурьтай байна. Харин 40 хувь энэ асуудлыг мэдэхгүй гэж хариулжээ.


Байгаль нуурт цутгадаг Монгол Улсын гол мөрөн дээр усан цахилгаан станц барихыг ОХУ эсэргүүцдэг билээ. ОХУ-ын энэ байр суурьтай 30 хувь нь санал нийлнэ, 35 хувь нь санал нийлэхгүй гэж хариулсан, бас гуравны нэг нь мэдэхгүй гэсэн байна.

Монгол Улсад шашны эрх чөлөөг хүндэтгэдэг учраас гадаадын шашны

байгууллагын үйл ажиллагааг хатуу хянах шаардлагагүй гэсэн хариултыг 28 хувь нь дэмжиж, 42 хувь нь дэмжихгүй, хатуу хяналт шаардлагатай гэж үзсэн бол 30 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Эндээс харахад судалгаанд оролцсон залуучуудын гуравны нэг нь гадаад бодлогын тодорхой асуудлаар ойлголт, сонирхол байхгүй байна гэж дүгнэж болохоор байна (График 24).


График 24: Та дараах байр суурьтай санал нийлэх үү?



Судалгаанд эдийн засгийн харилцаа, ялангуяа, чөлөөт худалдааны хэлэлцээрийн тухай мэдлэгийг шалгах зорилготой дараах асуултад 76 хувь

нь мэдэхгүй, дөнгөж 24 хувь нь Япон, Монголын хоорондын чөлөөт худалдааны гэрээ байгуулсныг мэднэ гэж хариулжээ (График 25).

График 25: Монгол Улс Япон улстай чөлөөт худалдааны гэрээ байгуулсан талаар та мэдэх үү?




Манай улсын бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нар болон аюулгүй байдал, гадаад бодлого судлаачдын

хувьд хамгийн их маргаан дагуулдаг асуудал болох Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын

гишүүнчлэлийн асуудлаар санал асуухад, судалгаанд оролцсон залуучуудын 53 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Оролцогчдын 27 хувь нь

гишүүнээр элсэх нь зөв гэж үзсэн бол, 20 хувь нь буруу, гишүүнээр элсэх шаардлагагүй гэжээ (График 26).


График 26: Монгол Улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элсэх нь зөв үү?



Нийт оролцогчдын 77 хувь нь Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулахыг дэмжиж, оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна. Мэдэхгүй гэсэн хариулт гарсангүй (График 27). Нэгэнт судалгаанд оролцогчдын дийлэнх олонх нь энхийг сахиулах ажиллагаанд

оролцохыг дэмжсэн байр суурьтай байгаа учраас дараагийн судалгаанд энэ асуултыг оруулахдаа НҮБ болон бусад цэргийн эвсэл, олон улсын зохион байгуулсан цэргийн ажиллагаа гэсэн ялгамжтай байдлаар томъёолж, илүү нарийвчилсан байр суурийг эрэлхийлэх боломжтой юм.

График 27: Таны бодлоор Монгол Улс олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцоогоо нэмэгдүүлэх хэрэгтэй юу?




ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Зөөлөн хүчний бодлого ба шинэ залуу үе

Орчин үеийн олон улсын харилцаанд зөөлөн хүчний бодлого улам бүр дэлгэрсээр байна. Улс орнуудын энэхүү бодлого нь тухайн улсын хэл, шашин, соёл урлаг, боловсрол, үндэсний үнэт зүйл, гадаад бодлогын манлайллаар бусдыг татах байдлаар дамжин хэрэгжиж байна. Монголын залуу үеийнхэнд зөөлөн хүчний бодлого хэрхэн нөлөөлж байгааг судалж үзэхэд хэд хэдэн сонирхолтой дүн гарлаа.

Манай залуучууд Америк, Япон, Өмнөд Солонгост хамгийн их суралцах хүсэлтэй байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүдэд БНСУ-д суралцах сонирхол давамгайлж байгаа юм (График 28). Залуучуудын

олонх нь монголчууд олноор ажиллаж, амьдардаг АНУ, БНСУ, Японыг дурдсан нь эдгээр улсад суралцахын зэрэгцээ хөдөлмөрлөх боломж илүүтэй байдагтай холбоотой байж болох юм. Фокус бүлгийн ярилцлагаас үзэхэд, залуучууд аливаа гадаад улсыг суралцахаар сонгохдоо туслалцаа авах боломжтой хамаатан садан, найз нөхөд, гэр бүлийнхэн нь байгаа эсэхэд ихээхэн ач холбогдол өгдөг болох нь харагдсан. Мөн фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын зарим нь өмнө нь дээр дурдсан улсууд, ялангуяа БНСУ-д ажиллаж, амьдарсан туршлагатай учраас амархан “хөлөө олох” боломжтой хэмээн хариулж байна.

График 28: Та гадаад улсад суралцах боломжтой болбол эдгээр улсаас алийг нь сонгох вэ?



Залуучууд гол төлөв Англи-Америк болон Солонгос кино сонирхон үзэж байна. Ялангуяа эмэгтэйчүүд солонгос

кинонд илүү дуртай байгаа юм (График 29).

График 29: Дараахаас аль улсын кино, телевизийн бүтээлийг гол төлөв үзэх дуртай вэ?



Судалгаанд оролцсон залуучуудын 62 хувь нь англи хэл, 29 хувь нь хятад, 26 хувь нь солонгос хэл сурах сонирхолтой байна (График 30). Англи хэл нь барууны орнуудад сурч, ажиллах болон дэлхийн түгээмэл хэл, хятад хэл нь хөрш орны хэл гэдэг утгаараа залуус сурах сонирхол их байдаг бол солонгос хэл сурах хүсэл эрмэлзэл нь солонгос кино их үзэж, солонгос хоол идэж, тэдгээрийг

даган дуурайх хандлага нэмэгдсэнтэй холбоотой байж болзошгүй. Учир нь судалгаанд оролцсон залуусын дийлэнх нь солонгос хоолонд хамгийн их дуртай гэж хариулжээ. Ялангуяа эмэгтэйчүүд солонгос кино үзэж, солонгос хоол, дуу хөгжимд дурлаж байгаа нь соёл, урлагаар дамжсан Солонгосын зөөлөн хүчний бодлогын нөлөө байх үндэстэй. (График 31-32).

График 30: Та аль нэг гадаад хэлийг суралцах боломжтой тохиолдолд доорхоос алийг нь сонгох вэ?




График 31: Гадаад хоолноос таны хамгийн дуртай нь аль нь вэ?





График 32: Дараахаас аль улсын дуу, хөгжмийн бүтээлийг гол төлөв сонсох дуртай вэ?



ДҮГНЭЛТ

- Монголын залуучууд гадаад үйл явдлын мэдээ, олон улсын харилцааны асуудлыг багагүй сонирхдог болох нь тус судалгаанаас харагдлаа. Залуучуудын гуравны нэг нь гадаад мэдээг “Их сонирхдог” гэж хариулсан бол тал орчим хувь нь “Хааяа сонирхдог” гэсэн хариултыг сонгожээ. Гадаад үйл явдлын мэдээг сонирхдоггүй оролцогчид 20 орчим хувийг эзэлж байгаагаас үзвэл монголын залуучууд гадаад бодлого, олон улсын үйл явдлыг ихээхэн сонирхож байна.
- Эдгээр залуусын олонх нь буюу 40.2 хувь нь гадаад үйл явдлын мэдээг нийгмийн сүлжээгээр дамжуулан хүлээн авдаг бөгөөд 55 хувь нь монгол хэлээр, 35 хувь нь англи хэлээр хүлээн авч байна.
- Дэлхий дахинд одоогоор цар тахал, ядуурал, эдийн засгийн хөгжлийн асуудал тулгамдаж байна хэмээн залуус харж байна. Харин Монгол Улсын хувьд гадаад улсаас эдийн засгийн хараат байдалд орох нь аюулгүй байдлын хамгийн том эрсдэл гэж хариулжээ. Харин дайн, мөргөлдөөний асуудалд монголын залуучууд ач холбогдол өгөхгүй байна.
- Фокус бүлгийн ярилцлагад даяаршил, мэдээллийн үлэмж их урсгалын нөлөөгөөр хүүхэд, залуусын оюун санаа, сэтгэлгээ гадны хэл, шашин, соёл иргэншлийн түрлэгт өртөж, энэ нь улс орны ирээдүйд томоохон эрсдэл учруулна гэдгийг онцолж байна.
- Гадаад дуу хөгжим, кино урлагаар дамжсан үзэл суртал, соёлын үр нөлөө залуусын оюун санаанд багагүй нөлөө үзүүлж байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын олонх нь Солонгос, барууны кино үзэх дуртай, Англи-Америк болон Хятад, Солонгосын дуу хөгжим сонсож, солонгос хоолыг хамгийн сайханд тооцож, эдгээр улсад сурч, ажиллах амьдрах сонирхол дүүрэн байна.
- Залуусын гадаад орнуудын тухай ойлголтыг судалж үзэхэд БНСУ, ОХУ, Япон, АНУ зэрэг улсуудын талаар эерэг, БНХАУ-ын талаар сөрөг сэтгэгдэл давамгайлж байна. Эдгээр улсуудаас дэлхийн хоёр нөлөө бүхий улсыг онцлон ирээдүйн төсөөллийг тодруулахад 76 хувь нь Хятадыг дэлхийн эдийн засгийг тэргүүлэгч улс гэж хариулсан бөгөөд ирээдүйд дэлхийн асуудлыг шийдвэрлэгч, 41 хувь нь эзлэн түрэмгийлэгч болж магадгүй гэж үзэж байгаа юм. Харин АНУ-ын ирээдүйн тухай төсөөлөлд 38 хувь нь “АНУ-ын нөлөө ирээдүйд нэмэгдэнэ”, 30 хувь нь “Нөлөө нь хэвээр байна”, харин 15 хувь нь “АНУ-ын нөлөө буурна” гэж хариулжээ.

- Дэлхийн улс орнуудын удирдагчдаас ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин, БНХАУ-ын Дарга Си Зиньпин нарыг санал асуулгад оролцсон залуус хамгийн сайн удирдагчаар нэрлэсэн бол фокус бүлгийн ярилцлагад ХБНГУ-ын Канцлер асан Ангела Меркелийг хамгийн сайн удирдагч гэдгийг онцолжээ.
- Монгол Улсын гадаад бодлогын хувьд гадны хөрөнгө оруулалтыг татаж, тогтвортой хадгалах, гадаад худалдааг төрөлжүүлэх асуудалд хамгийн их анхаарал хандуулах ёстой бөгөөд уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай манай улсын хувьд байгалийн баялагийг зүй зохистой ашиглаж чадвал хурдацтай хөгжиж чадна гэж залуучууд үзэж байна.
- Хөрш орнуудын талаарх залуучуудын сэтгэгдлийг тандаж үзэхэд 90 орчим хувь нь БНХАУ болон ОХУ бол Монгол Улсын ойрын түнш гэж хариулжээ. Манай улсын газар зүйн байршил энэхүү хариултад гол нөлөө үзүүлсэн байж болзошгүй. Гэхдээ бусад орнууд буюу Япон, АНУ, ХБНГУ зэрэг орнууд Монгол Улсын ирээдүйд багагүй нөлөөтэй болох нь тус судалгаанаас харагдаж байна.
- Монголын залуучуудын хувьд БНХАУ-ыг нэг талаар “болгоомжлох ёстой улс”, нөгөөтэйгүүр “эдийн засгийн боломж” гэж хардаг бол ОХУ-ын тухайд эдийн засгийн боломж, хуучны түнш орон гэх хандлага давамгайлж байна. Хоёр хөршийн талаар хариултыг харьцуулж үзэхэд БНХАУ-ыг болгоомжлох ёстой улс, аюул занал гэдэг байдлаар, ОХУ-ыг хуучны түнш, эдийн засгийн боломж гэж харж байна. Гэхдээ фокус бүлгийн ярилцлагад ОХУ нь манай улсыг шатахууны үнийн хэт хараат байдалд оруулж байгаа нь ОХУ-ын талаар сөрөг ойлголт төрүүлсэн гэдгийг онцолжээ.
- Гадаад бодлогын зарим асуудлаар залуусын байр суурийг судалж үзэхэд аливаа асуудалд аль нэг хариултыг туйлширч дэмжихгүй байна. Тухайлбал, Байгаль нуурт цутгадаг Монгол Улсын гол мөрөн дээр усан цахилгаан станц барихыг ОХУ эсэргүүцдэг тухай асуудалд ОХУ-ын байр суурьтай 30 хувь нь санал нийлж, 35 хувь нь санал нийлэхгүй байна. Мөн 35.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Монгол Улсад шашны эрх чөлөөг хүндэтгэдэг учраас гадаадын шашны байгууллагын үйл ажиллагааг хатуу хянах шаардлагагүй гэсэн байр суурийг 28 хувь нь дэмжиж, 42 хувь нь дэмжихгүй, хатуу хяналт шаардлагатай гэж үзжээ. Энэ нь сүүлийн жилүүдэд шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө нэрийн дор олон улсад үйл ажиллагааг нь хориглодог

шашны байгууллагууд Монгол Улсад олноор үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой байж болох юм.

болон эвслийн цэргийн ажиллагааны ялгааны хувьд тодорхой ойлголтгүй байгаа бололтой.

- Далай ламын айлчлалаас болоод Монгол Улсад эдийн засгийн хохирол учирдаг учраас Далай ламыг айлчлуулах шаардлагагүй гэж 28 хувь нь үзсэн байхад, 32 хувь нь эсрэг байр суурьтай байна. Харин 40 хувь нь энэ асуудлыг мэдэхгүй гэж хариулжээ. Энэхүү судалгаанд оролцсон залуучуудын гуравны нэг нь гадаад бодлогын тодорхой асуудлаар ойлголтгүй гэж үзэж болохоор байна.
- Манай улсын улс төрчид болон аюулгүй байдал, гадаад бодлого судлаачдын хувьд хамгийн их маргаан дагуулдаг Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад элсэх талаар залуучуудын саналыг асуухад 53 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Мөн оролцогчдын 27 хувь нь гишүүнээр элсэх нь зөв гэж үзсэн бол 20 хувь нь буруу, гишүүнээр элсэх шаардлагагүй гэж үзэж байна.
- Нийт оролцогчдын 77 хувь нь Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулахыг дэмжиж, оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна. Мэдэхгүй гэсэн хариулт гараагүй. Харин залуучууд НҮБ-ын

ХАВСРАЛТ: Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлт

Судалгаанд оролцогчдын 66 хувь нь Улаанбаатар хот, 23 хувь нь Эрдэнэт хот, 6 хувь нь Төв аймаг, 5 хувь нь

Булган аймгаас оролцсон бөгөөд нийт оролцогчдын 58 хувь нь эмэгтэй, 42 хувь нь эрэгтэй байна (График 1-2).

График 1:




График 2:



Судалгаанд оролцогчдын насны бүтцийн эзлэх хувь ойролцоо гарсан бөгөөд 99 хувийг 16-35 насны залуус эзэлж байсан бол 1 хувийг 36-41 настай хүмүүс эзэлсэн байна (График 3).

Ажил эрхлэлтээр нь үзвэл 39 хувь нь хувийн хэвшилд, 25 хувь нь төрийн албанд ажилладаг бол 15 хувь нь оюутнууд, 14 хувь нь ажилгүй залуус байна (График 4).

График 3:




График 4:



Зохиогчийн тухай:

Бодлогын инновацийн хүрээлэн нь 2016 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа хийх, сургалт семинар зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилготой нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага болно.

Импрессиум

© 2021 Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар

Ландмарк төв
Сүхбаатар дүүрэг 1-р хороо
Чингисийн өргөн чөлөө 13
Шуудангийн хайрцаг 831
14251 Улаанбаатар
Монгол Улс

Агуулгын хариуцлагыг:
Бенедикт Ивановс | Монголыг
хариуцсан суурин төлөөлөгч

Фэйсбүүк: [facebook.com/fesmongolia](https://www.facebook.com/fesmongolia)
Цахим хуудас: <https://mongolia.fes.de/>
Цахим шуудан: info@fes-mongolia.org

ФЭС-ээс эрхлэн гаргасан бүтээлийг тус сангаас бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор ашиглахыг хориглоно.



1925 онд байгуулагдсан Фридрих-Эбертийн сан нь Германы хамгийн ууган уламжлалт улс төрийн сан юм. Манай сан Германы эзэнт улсын анхны ардчилсан ерөнхийлөгч Фридрих Эбертийн гэрээслэлийн дагуу байгуулагдаж түүний нэрээр нэрлэгдсэн юм. Фридрих-Эбертийн сангийн улс төрийн өв, гүйцэтгэж буй үүрэг нь түүний үзэл санаа, гэрээслэлээс эхтэй.

ФЭС нь Монгол Улс 1990 онд Ардчилсан тогтолцоонд шилжсэн цагаас эхлэн тус улсад ардчилал, нийгмийн шударга ёсыг дэмжин ажиллаж байна.